



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ХУРААНГУЙ ТАЙЛАН

**АУДИТЫН СЭДЭВ: ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 2023 ОНЫ ОРОН НУТГИЙН
НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**Аудит хийсэн
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаал, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

**ТӨСӨВТ ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХДЭЭ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫГ 111.6 САЯ
ТӨГРӨГӨӨР НЭМЖ БАТАЛСАН БАЙНА**

Аудитын тайланг Дархан-Уул аймгийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тус тус хүргүүлсэн.

Дархан-Уул аймаг

2024 оны 04 дүгээр сар

Аудитын харилцан хамаарал

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т “аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасан.

Аудитын зорилго, зорилтууд

Дархан-Уул аймгийн 2023 оны төсвийг үндэслэлтэй төлөвлөж, гүйцэтгэлийг үр ашигтай зарцуулж, үнэн зөв тайлагнасан эсэхэд дүгнэлт гарган, аймгийн удирдлагад танилцуулах зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. Төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, бүрэн биелсэн эсэх
2. Төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан эсэх;
3. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд хүрсэн эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2023 оны батлагдсан төсөв, аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүний хэрэгжилт болон бусад судалгаа, материалд тулгуурлан гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, аймгийн ИТХ-ын тогтоолоор төсөвт 2 удаа өөрчлөлт орж, төсвийн орлогыг 39,661.9 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих орлогыг 11,899.2 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 13,473.2 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн орлогыг 680.4 сая төгрөг, нийт төсвийн орлогыг 65,714.7 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 2023 оны нийт орлогыг 65,714.7 сая төгрөгөөр төлөвлөж, 75,565.6 сая төгрөг буюу 114.9 хувиар биелсэн байна. Харин урсгал орлогыг 40,322.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 50,284.1 сая төгрөг буюу 124.7 хувиар давж биелжээ.

Аймгийн төсвийн нийт зарлагыг 65,714.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр урсгал зардалд 32,838.3 сая төгрөг, хөрөнгийн зардалд 18,454.1 сая төгрөг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд 838.8 сая төгрөг, нийт 52,131.2 сая төгрөг зарцуулж, 79.3 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 9,961.3 САЯ ТӨГРӨГӨӨР БУЮУ 124.7 ХУВИАР ДАВЖ БИЕЛСЭН БАЙНА

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны 58 дугаар тогтоолоор төсвийн орлого, зарлагыг 61,861.0 сая төгрөгөөр баталсан байна. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, аймгийн ИТХ-ын тогтоолоор төсвийн орлогод 2 удаа өөрчлөлт оруулжээ.

Хүснэгт 1. Орлогын төсвийн төсөл, батлагдсан төсөө

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Анх баталсан төсөв /2022.12.02/ №58	Тодотгол /2023.07.05/ №43	Зохицуулалт /2023.11.24/ №53
	Орон нутгийн төсвийн орлого	45,703.1	43,605.1	40,230.6	40,322.7
1	Татварын орлого	41,000.9	34,874.0	36,357.7	36,390.7
1.1	ХХОАТатвар	29,349.9	25,978.1	28,478.1	29,098.1
1.2	ХХХОАТ-ын буцаалт	(1,975.9)	(3,000.0)	(2,558.6)	(2,558.6)
1.3	ААНОАТатвар	5,644.0	4,500.0	700.0	700.0
1.4	Хөрөнгийн албан татвар	3,855.1	3,184.3	3,721.7	3,434.7
1.5	Бусад татвар /төлбөр хураамж/	4,127.8	4,211.6	6,016.5	5,716.5
2	Татварын бус орлого	4,702.2	8,731.1	3,872.9	3,932.0
2.1	Хүү, торгуулийн орлого	2,503.6	1,270.0	1,742.0	1,702.6
2.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	350.8	278.5	520.5	579.6
2.3	Бусад орлого	1,148.2	680.0	930.0	969.4
2.4	Хоршоо хөгжүүлэх сангийн орлого	699.6	680.4	680.4	680.4
2.5	Хүүгийн орлого	-	5,822.2		

Аймгийн ИТХ-ын 2023 оны 43 дугаар тогтоолоор төсвийн тодотгол хийж татварын орлогыг 1,483.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Засгийн газрын 2023 оны 241, 242 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор сумдын цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 1,835.0 сая төгрөгөөр өссөн, газрын дуудлага худалдааны орлогоор 1,800.0 сая төгрөг төвлөрсөн зэргээс шалтгаалжээ.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 53 дугаар тогтоолоор төсвийн зохицуулалт хийхдээ аймгийн төсөвт байгууллагын өөрийн орлогын гүйцэтгэлд үндэслэн 51.8 сая төгрөгөөр нэмсэн бол Орхон сум төлөвлөөгүй малын тоо толгойн албан татварын орлогыг 33.0 сая төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлийг 19.5 сая төгрөг, өөрийн орлогыг 7.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлснээр нийт орон нутгийн төсвийн орлогыг 111.6 сая төгрөгөөр нэмж баталжээ. Төсвийн зохицуулалтаар орлогыг 111.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2¹, 42.2.1а², 42.2.1б³ дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Хүснэгт 2. Төсвийн орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 он				Өмнөх оны зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
Татварын орлого	41,000.9	36,390.7	44,732.0	8,341.3	122.9	3,731.1
ХХОАТ	29,349.9	29,098.1	36,547.8	7,449.7	125.6	7,197.9
ХХОАТ-ын буцаалт	(1,975.9)	(2,558.6)	(2,558.6)	-	100.0	(582.7)
ААН-ын орлогын албан татвар	5,644.0	700.0	87.9	(612.1)	12.6	(5,556.1)

¹ төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно

² өөрийн төсийн багцад хамаарах хөтөлбөр хооронд

³ түүнд шууд харьяалагдах төвлөрүүлэн захирагчдын төсөө хооронд

Хөрөнгийн албан татвар	3,855.1	3,434.7	3,853.7	419.0	112.2	(1.4)
Бусад татвар	4,127.8	5,716.5	6,801.2	1,084.7	119.0	2,673.4
Татварын бус орлого	4,002.6	3,932.0	5,552.0	1,620.0	141.2	1,549.4
Хүү, торгуулийн орлого	2,503.6	1,702.6	2,995.1	1,292.5	175.9	491.5
Төсвийн байгууллагын өөрийн орлого	350.8	579.6	574.5	(5.1)	99.1	223.7
Бусад орлого	1,148.2	969.4	1,285.0	315.6	132.6	136.8
Хоршоо хөгжүүлэх сангийн орлого	699.6	680.4	697.4	17.0	102.5	(2.2)
Нийт дүн	45,003.5	40,322.7	50,284.0	9,961.3	124.7	5,280.5

Засгийн газрын 2023 оны 241, 242 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн доод хэмжээ нэмэгдсэн, орон нутгийн нэмэгдлийг 60-80 хувиар олгож эхэлсэн зэргээс шалтгаалан цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 5,809.9 сая төгрөг, бусад татвар хураамж 1,084.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь татварын орлого өмнөх оноос 3,731.1 сая төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ.

Аймгийн татварын орлого төлөвлөснөөс 22.9 хувиар буюу 8,341.3 сая төгрөгөөр давж биелсэн нь:

- Төрийн албан хаагчдын болон ААН байгууллагын цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого нэмэгдсэнээр 5,809.9 сая төгрөг, арилжааны банкны хадгаламжийн хүү өссөнөөр иргэдийн хадгаламж өмнөх оноос 73,809.3 сая төгрөгөөр нэмэгдсэнээр хадгаламжийн хүүгийн орлого 352.6 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн өсөлт, ипотекийн зээлийн олголттой холбоотойгоор хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 698.2 сая төгрөгөөр тус тус давж биелснээр ХХОАТ-ын орлого 7,449.7 сая төгрөгөөр,
- Дуудлага худалдааны орлогын гүйцэтгэлээр 622.9 сая төгрөг, аймгийн ИТХ-ын тогтоолоор Түгээмэл тархацтай АМНАТ-ийн тусгай зөвшөөрлийг 12 татвар төлөгчид олгож, ногдлоор 46.8 сая төгрөг, Хараа ерөө голын сав газар, байгаль орчны газартай ус ашиглах гэрээг шинэчилснээр үүссэн ногдлын төлбөрийг барагдуулснаар 98.2 сая төгрөгөөр тус тус давж биелснээр бусад татварын орлого 1,084.7 сая төгрөгөөр давж биелжээ.

БҮЛЭГ 2. АЙМГИЙН УРСГАЛ ЗАРДЛЫГ 13.1 ХУВЬ БУЮУ 4,933.1 САЯ ТӨГРӨГИЙН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр аймгийн төсвийн суурь зарлагыг 2,059.5 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 963.5 сая төгрөгөөр тус тус бууруулж, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 2,661.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

Дүрслэл 1. Төсвийн зарлагын тодотгол /сая төгрөг/



Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 43 дугаар тогтоолоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1-т “Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэсэн заалтыг үндэслэн аймгийн 2023 оны төсөвт тодотгол хийж төсвийн зарлагыг 3,742.0 сая

төгрөгөөр нэмэгдүүлжээ. Энэ нь Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл"-ийн 5,822.2 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсан, Засгийн газрын 2023 оны 241, 242 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн доод хэмжээ, орон нутгаас олгох төрийн захиргааны албан хаагчдын нэмэгдлийг 60-80 хувиар нэмэгдүүлснээр цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,566.3 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг 2,661.6 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтыг 4,807.4 сая төгрөг, төсвийн байгууллагын бараа, ажил үйлчилгээний урсгал зардлыг 487.8 сая төгрөгөөр тус тус нэмж баталсантай холбоотой байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 53 дугаар тогтоолоор Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1.а, 42.2.1г дэх заалтуудыг үндэслэн аймгийн 2023 оны төсөвт зохицуулалт хийхдээ төсвийн зарлагыг 111.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд:

- Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд 16.6 сая төгрөг,
- Хуримын ордны үйл ажиллагаанд 30.0 сая төгрөг,
- Биеийн тамир спортын газрын засварын зардалд 5.2 сая төгрөг,
- Орхон сумын хоршоо хөгжүүлэх санг 19.5 сая төгрөг,
- Орхон сумын ОНХС-г 33.0 сая төгрөг,

Засаг даргын нөөц санг 7.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсан нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2⁴ 42.4⁵, 42.7⁶, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 2.17-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Аймгийн орон нутгийн 2023 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлд 65,714.7 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 52,131.2 сая төгрөг зарцуулсан нь аймгийн ДНБ-ий 13.3 хувьтай тэнцэж байна. Нийт зардлын гүйцэтгэл 79.3 хувьтай гарсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 5,758.9 сая төгрөгөөр буурсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 53 дугаар тогтоолоор баталснаар Дархан сум 18,050.9 сая төгрөг, Хонгор сум 2,234.8 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлж, Орхон сумд 923.4 сая төгрөг, Шарын гол сумд 481.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, аймгийн төсвөөс улсын төсөвт 892.6 сая төгрөгийг 100 хувь төвлөрүүлжээ

БҮЛЭГ 3. ТЕЗ-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ ЗОРИЛТОТ ТҮВШИНД ХҮРСЭН БОЛОВЧ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.

Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2020 оны 02/08 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 267 зорилт, 318 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас тайлант онд 66 зорилт, 300 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, нийт 948.8 сая төгрөг баталснаас урсгал зардалд 649.2 сая, хөрөнгийн зардалд 224.8 сая, нийт 874.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, "Алсын хараа 2050", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогыг аймаг орон нутагтаа хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Аймгийн ТЕЗ-ийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хоорондын уялдааг харуулбал:

⁴ Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно:

42.2.1 төсвийн ерөнхийлөн захирагч нь:

42.2.1.а өөрийн төсвийн багацад хамаарах хөтөлбөр хооронд;

42.2.1.б түүнд шууд харьяалагдах төвлөрүүлэн захирагчдын төсөв хооронд;

42.2.1.в төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчдын төсөв хооронд;

42.2.1.г түүнд шууд харьяалагдах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд.

42.2.2 төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд;

42.2.3 төсвийн шууд захирагч нь зөвхөн өөрийн урсгал зардалд.

⁵ Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна

⁶ Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.

⁷ Төсвийн захирагч дор дурдсан нөхцөлд батлагдсан төсөвтөө зохицуулалт хийж болно:

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээтэй уялдсан байдал

№	Хөтөлбөрийн нэр	Арга хэмжээний тоо	Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3	3.3.1, 3.4.3	138-140, 145-149
2	Засаг даргын тамгын газар	5	1.4.1.5, 2.6.1, 3.1.1, 3.1.2, 3.1.3	21, 102-108, 129-135
3	Хотын захирагчийн алба	1	2.7.2, 5.1.2	115-123, 174-176
4	Засаг дарга	11	1.5.4, 1.5.7.3, 2.1.2, 2.1.3.2, 2.3.1.5, 2.3.2.5, 2.6.1.7, 2.6.2, 2.7.1.4, 3.2.1, 5.1.3.5	43-46, 50, 63, 67, 80, 87-90, 109-111, 114, 136, 137, 179
5	Орон нутгийн хүүхдийн зуслан амралт	1	1.5.9.2	53
6	Аймгийн халамжийн сан	1	1.5.1	36, 37
7	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	2	4.1.2.4, 4.1.2.6	156, 157
8	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	1	2.1.2	67
9	Орон нутгийн өмчийн газар	1	2.1.1	60-62
10	Мэргэжлийн боловсрол	1	1.4.1.4	35
11	Сум дундын ойн анги	1	4.1.3.1	158
12	Соёл, урлаг, Биеийн тамир, спорт	1	1.2.1, 1.6.1	11-14, 55-59
13	Ахмад хөгжлийн төв	1	1.1.2.2	6

Эх сурвалж: Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар

Дээрх хүснэгтээс харахад ТЕЗ-ийн 2023 онд хэрэгжүүлэх 13 хөтөлбөрийн 30 арга хэмжээг аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөнд тусгасан арга, хэмжээ, Монгол Улсын хөгжлийн урт, дунд болон богино хугацааны баримт бичгүүдийн зорилт, арга хэмжээнүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Аймгийн орон нутгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5⁸, 54.5.4⁹-д заасантай нийцэхгүй байна.

Аймгийн орон нутгийн 2023 оны төсөвт 2 удаа тодотгол хийж, ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанар болон тоо хэмжээнд өөрчлөлт оруулснаар ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 1,330.8 сая төгрөг, ОНТХО-аар шинээр хэрэгжих ТАХ-нд 4,750.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7¹⁰-д заасантай нийцэхгүй байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2023 онд хэрэгжүүлэх, хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийн хэрэгжилтийг тайлагнаагүй, үнэлгээ хийж, баталгаажуулаагүй тул хүрэх үр дүнгийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.

⁸ Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

⁹ хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/;

¹⁰ Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.

ДҮГНЭЛТ:

Аудитаар цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлээгүйгээс төсөвт зохицуулалт хийхдээ орлого, зарлагыг 111.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.
2. Орхон сум, Шарын гол сумын төсвийг батлахдаа малын тоо толгойн албан татварын орлогыг төлөвлөгөөнд тусгаагүй байна.
3. Аймгийн ИТХ-ын төсөвт 165.0 сая төгрөгийн төлөөлөгчдийн урамшууллын зардлыг баталсан нь Засгийн газрын 2022 оны 404 дүгээр тогтоолтой нийцэхгүй байна.
4. “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, хот, хөдөөгийн сэргэлтийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн байна
5. Аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хуульд заасны дагуу тайлагнаагүй, үр дүнг үнэлж, баталгаажуулаагүй байна.
6. Тодотголоор баталсан 4,750.0 сая төгрөгийн 104 төсөл, арга хэмжээний 49 хувь буюу 2,328.7 сая төгрөгийн 26 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Аудитын дүнд үндэслэн аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагч Б.Азжаргалд зөвлөх нь:

1. Төсвийн зохицуулалт хийхдээ Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасныг баримталж, батлагдсан төсвийн нийт дүнд өөрчлөлт оруулахгүй байх
2. Сумдын ТЕЗ-ийн төсвийн орлогыг батлахдаа малын тоо толгойн албан татварын орлогыг батлах чиглэл өгч, хяналт тавих
3. Аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хуульд заасны дагуу тайлагнаж, хүрэх үр дүнг үнэлж, баталгаажуулах
4. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т заасны дагуу төсвийг үр ашигтай байхаар төлөвлөж, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж байх